



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 5/19

Чингис хот

Б.Оюунбаатарт сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1, 131.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын санхүүгийн бүртгэл тайлангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, санхүүгийн тайлангын аудитаар “хязгаарлалттай” санал дүгнэлт авсан Дадал сумын Засаг дарга Б.Оюунбаатарт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Санхүүгийн тайланд бүртгэлээр тавих хяналтаа эрс сайжруулж ажиллахыг Б.Оюунбаатарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захиргааны актыг эс хүлээн зөвшөөрвөл албан ёсоор гардаж авсанаас хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА